

Х-1, Д-1, ХН-113, Нугалбар-7

**ЗАРГА ЗАЙЛХАЙ ЭСГЭГЧИД БА ГЭРЧ ЗЭРГИЙН ХҮМҮҮСИЙГ АЛБАНЫ ГАЗАР
ЗАРЛАН ИРҮҮЛЭХ ДҮРЭМ**

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. Албаны яамны газар зарлан ирүүлэх хүмүүсд урьдаар зарлах бичиг илгээвээс зохимуй.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ. Зарлах бичигт тодорхойлон мэдэгдэх нь

1. Зарлан ирүүлэх хүний аймаг, хошуу, нутаг захиргаа нэр овог
2. Зарлан гаргасан албаны газар ба ирүүлэх болзоо
3. Уг хэргийн учир ба жич зарлан ирүүлэх хэрэг үүсгэгсэд ба уг ялт нар гэрч эксперт хэмээх хэрэг тодорхойлох хүмүүсүүд болмуй.
4. Зарлахуйд эс ирэгчдийг шийтгэх зүйл ба мөн зарлах бичигт албаны газрын түшмэл гар тавибаас зохимуй.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ. Зарлах бичгийг харьяат газрын зарлага ба цагдан сэргийлэх буюу нутгийн захиргаагаар уламжлуулан тушааваас зохимуй.

ДӨРӨВҮГЭЭР ЗҮЙЛ. Зарлах бичгийг зарлан ирүүлэх хүнд тушаах болвоос хэрэв түүний бие гэртээ байхгүй болвоос гэрийн тэргүүлэгчийн зэрэг томьёо бүхий ойрын хүмүүст тушаан өгч болох тул урьдаар тэдгээрийн зөвшөөрлийг авч гарын үсэг зуруулан уг бичгийг өгч уламжлуулваас зохимуй.

ТАВДУГААР ЗҮЙЛ. Зарлах бичигт тушаасан өдөр сарыг бичихээс гадна хүлээн авагсдын үсэг зурсан хуудас нэгэн хувийг зарласан юманд эгүүлэн тушааж байцаах тэмдэг болгомуй.

ЗУРГААДУГААР ЗҮЙЛ. Хэрэв зарласан бичгийг хүлээн авсан хүн бичиг үл мэдэх буюу үсэг зурахыг хүлээхгүй аваас уг бичгийг хүргэж очсон албаны хүмүүс уг бичигт сар өдөр ба, түүний үсэг зурсангүй учрыг тайлбарлан хүргэн тушааснаа тэмдэглэн бичвээс уул бичгийг тушаан авахуулсантай чанар адил болмуй.

ЗАРЛАХУЙД ЭС ИРЭГЧДЫГ ШИЙТГЭХ ЗҮЙЛҮҮД НЬ

ДОЛООДУГААР ЗҮЙЛ. Эрүүгийн хэргийн ялт хүмүүс үл ирэх бөгөөд учир шалтгааныг урьдаар гаргасангүйг нь цагдан сэргийлэхийн зэрэг албаны хүмүүст тушааж бариулан итгүүлмуй.

НАЙМДУГААР ЗҮЙЛ. Иргэний хэрэгт холбогдсон хоёр этгээдэд зарлах бичиг тушаасан нь лавтай бөгөөд хэрэв тэд нар зарласан болзоонд жинхэнэ холбогдогсдын биес буюу төлөөний хүнийг эс ирүүлвээс хэргийг шууд шийтгэж болмуй. Үүнд тайлбарлахуй нь, хэрэв юм нэхвэрлэсэн этгээд мөн зарласан болзоонд өөр буюу төлөөний хүнийг эс ирвээс түүний хэргийг хэлэлцэхгүй болгомуй.

ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ. Аливаа хүнд энгийн дарлагдсан доромжлогдсоны учир заалдаад албаны газраас зарласан болзоонд өөр буюу төлөөний хүн эс ирвээс хэлэлцэхгүй болмуй.

АРАВДУГААР ЗҮЙЛ. Хоёрдугаар зүйлийн гуравдугаар ангид заасан гэрчийн зэрэг хүмүүс зарласан болзооноо эс ирвээс хэргийн учир ба тэд нарын хөрөнгө чинээг үзэж хорин таван төгрөгөөс дээш бус мөнгөний ял торгомуй.